

## **ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛЭЭС ГАРАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

“Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” УИХ-ын 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанк болон Засгийн газрын зүгээс шат дараалан авч байгаа арга хэмжээний явцын талаарх мэдээллийг 2015 оны 3 дугаар сарын 25-ны байдлаар нэгтгэн танилцуулж байна.

Засгийн газрын өнөөдрийн хуралдаанаар уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг баталснаар хэрэгжүүлэгч яамдууд болон бусад холбогдох байгууллага тус бүрийн үүрэг, хариуцлагыг нарийвчлан тогтоож өгөх юм.

“Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-т заасан нийт 12 зорилт бүхий 67 арга хэмжээнээс зөвхөн 2015 онд хийгдэх нийт 41 арга хэмжээ байх бөгөөд үүнээс 25-ыг нь 2015 оны эхний хагас жилд хэрэгжүүлэхээр тусгагдсан байна. Үүнд холбогдох яамдууд онцгой анхаарч ажиллаж байна.

Уг тогтоолыг хэрэгжүүлэхэд Засгийн газраас Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой нягт хамтран ажиллаж байгаа бөгөөд 41 дүгээр тогтоол батлагдснаас хойш 1 сарын хугацаанд багагүй ажлыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал,

- Өрийн удирдлагын тухай хууль 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан бол хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 3 дугаар сарын 9-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг батлаад байна.
- Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын (НӨАТ) тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хөрөнгийн албан татварын тухай хуулийн төсөл, Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэж байна.
- Гадаадын хөрөнгө оруулагчдад мэдээлэл, зөвлөгөө өгөх “Хөрөнгө оруулагчийн менежер” үйлчилгээг нэвтрүүлж, 2015 оны эхний 2 сарын байдлаар 50 гаруй хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээг хүргээд байна. Гадаадын хөрөнгө оруулалт бүхий 36 аж ахуйн нэгж 2015 оны эхний 2 сарын байдлаар шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.
- “Оюутолгой” ХХК шинэчилсэн ТЭЗҮ-ийг УУЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүлээлгэж өгөхөөр бэлтгэл ажлыг хийж байна.
- Концессын “барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэх “Эрдэнэт хотоос Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд байрлах Овоотын уурхайн чиглэлд барих төмөр замын төсөл”-ийн концессын гэрээг хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргуулахаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтоолын төслийг бэлтгээд байна

- “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу “усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам болон гэрээний загвар”-ыг боловсруулж, Засгийн газраас 2015 оны 4 дүгээр сарын 1-ний дотор батлан гаргахаар ажиллаж байна.
- Төмрийн хүдрийн баяжмалын экспортыг нэмэгдүүлэхийн тулд гадаадын зах зээлд борлуулсан төмрийн хүдэр, баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ноогдуулах борлуулалтын үнэлгээ тооцох аргачлалыг Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, аж ахуйн нэгжүүд нөөц ашигласны төлбөрөө бодит үнэлгээгээр тооцуулж, татварын хөнгөлөлт эдлэх боломжтой болголоо.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 10 хувиар, ажил гүйцэтгэх тендерийн үнийг 7.5 хувиар хийсвэрээр бууруулж тооцон давуу эрх олгож ажиллах чиглэл баримталж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 9 дүгээр зарлигаар үйлдвэржилтийг эрчимжүүлэх талаар Засгийн газарт өгсөн чиглэл болон УИХ-аас батлагдсан хөтөлбөрийн дагуу эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хүрээнд дараах эрх зүйн актууд батлагдаад байна. Үүнд:

- 1) УИХ-ын 2014 оны намрын чуулганаар эдийн засгийн зохицуулалт хийхэд чиглэгдсэн бие даасан 5 хууль, УИХ-ын 12 тогтоол тус тус батлагдсан байна. Уг хөтөлбөрт шинээр 9 хуулийн төсөл боловсруулахаар зааснаас Өрийн удирдлагын тухай хууль батлагдаж, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2015 оны 89 дүгээр тогтоол батлагдаад байна. Түүнчлэн, Казиногийн тухай хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан 3 дугаар сарын 30-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв.
- 2) Засгийн газрын зүгээс 2015 он гарсаар эдийн засгийн чиглэлээр 13 тогтоолыг тус тус батлаад байна
- 3) Монгол Улсад бизнес эрхлэх орчныг сайжруулах, концессын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээ болон БНХАУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг судлах зэрэг асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдын 9 захирамж гарч, Эдийн засгийн үндэсний хороог байгуулан, ажлын 4 хэсэг шинээр байгуулагдан ажиллаж байна.
- 4) Япон Улстай эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээрийг байгуулан ажиллаж байгаа бөгөөд Монголын эдийн засгийн форумыг энэ оны 4 дүгээр сарын 2-3-нд зохион байгуулагдана.

Уг хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг үр ашигтай, бодитой хэрэгжүүлэхэд Засгийн газраас Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой нягт хамтран ажиллах шаардлагатай байгаа бөгөөд салбарын яамдын хоорондын уялдаа холбоог хангаж ажиллахад анхааран ажиллаж байна.

-----ooOoo-----

## ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛЭЭС ГАРАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ БАЙГАА АЖИЛ

Нэгдүгээр чиглэл. Макро эдийн засгийг тогтворжуулах

Богино хугацаанд үр дүн гарах арга хэмжээ

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах этгээд	Хүрэх үр дүн		3 дугаар сарын 20-ны байдлаар авсан арга хэмжээ
					Харьцуулах суурь үзүүлэлт	2016 оны эцэст	
1.	<b>Төсвийн нэгдмэл, ил тод, хариуцлагатай бодлого хэрэгжүүлж, бизнесийг дэмжих</b>						
1.1.	Төсвийн нэгдмэл байдлыг хангаж, ил тод байдлыг дээшлүүлэн, алдагдлын хэмжээг зохистой түвшинд хүргэх	Нэгдсэн төсвийн 2016-2018 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд төсвөөс гадуурх зардлыг багтаасан нэгдсэн төсвийн алдагдал болон улсын өрийн ДНБ-д эзлэх хувийг үе шаттайгаар бууруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах	2016 он	Сангийн яам, Хөгжлийн банк	Төсвөөс гадуурх зардлыг багтаасан нэгдсэн төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь-5.0	Төсвөөс гадуурх зардлыг багтаасан нэгдсэн төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь-4.0	Монгол Улсын хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор дараах чиглэлээр ажиллаж байна. Үүнд: 1. Төсвөөс гадуур хийгдэж байгаа хөрөнгө оруулалтаас төсөвт үзүүлэх зохисгүй нөлөөллийг багасгах, 2. Хөгжлийн банкны үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, 3. Хөгжлийн банкны засаглалыг сайжруулах замаар бие даасан байдлыг хангах, дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох. 4. Хөгжлийн банкны эх үүсвэр татах, хөрөнгө оруулалт хийх бодлого, чиглэлийг зохистой болгох. Эдгээр ажлын үр нөлөөг сайжруулахын зэрэгцээ Хөгжлийн банкны эрх зүйн орчин, засаглалын тогтолцоог олон улсын нийтлэг зарчмуудад нийцүүлэн, олон улсын хөрөнгө санхүүгийн зах зээлд амжилттай ажиллахын тулд цаашид үе шаттайгаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний цогц төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн “Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай” 95 дугаар тогтоол батлагдсан. Хөгжлийн банк нь Засгийн газрын үнэт цаасаар бүрдүүлсэн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээ болон хөрөнгийн зарцуулалтын талаар олон нийтэд үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлж, ил тод байдлыг хангах ажлын хүрээнд <a href="http://www.dbm.mn">www.dbm.mn</a> цахим хуудсыг 2012 оны 9 дүгээр сараас ажиллуулж байна. <a href="http://www.dbm.mn">www.dbm.mn</a> цахим хуудасны бондын зарцуулалт хэсэгт ХБ-наас санхүүжүүлж буй төсөл, төслийн танилцуулга, тогтоолын дүн, гэрээний дүн, санхүүжүүлсэн дүн, хүчин чадал болон нийгэм, эдийн засгийн үр ашиг, ач холбогдол зэрэг мэдээллүүдийг салбар, бүс нутаг, эх үүсвэр тус бүрээр нь ангилан олон нийтэд мэдээлж байна.
		Хөгжлийн банкны бизнес төлөвлөгөө, санхүүгийн тайлан, төслүүдэд олгосон санхүүжилт, санхүүжилтийн нөхцөл, эргэн төлөлт зэрэг мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу нийтэд мэдээлэх	2015 оны эхний хагас жил	Сангийн яам, Хөгжлийн банк	Тайлан нийтлэгдээгүй	Хөгжлийн банкны бизнес төлөвлөгөө, санхүүгийн тайлан, төслийн санхүүжилтийн талаар мэдээлнэ.	
1.2.	Засгийн газрын	Өрийн удирдлагын	2015 оны	Сангийн	Улсын	Улсын өрийн 2016	Өрийн удирдлагын тухай хууль 2015 оны 2 дугаар

	өрийн удирдлагыг сайжруулах	тухай хуулийг Улсын Их Хурлаар батлуулж, өрийн менежментийг сайжруулах	эхний хагас жил	яам, Монголбанк	өрийн 2015 оны ДНБ-д эзлэх хувь-58.3	оны ДНБ-д эзлэх хувь-55.0	сарын 18-ны өдөр батлагдаж, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 3 дугаар сарын 9-ний өдрийн 89 дүгээр тогтоолоор хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг батлаад байна. Цаашид Засгийн газар өр үүсгэх, баталгаа гаргах бүхий л асуудал нь Өрийн удирдлагын тухай хуулийн хүрээнд зохицуулагдах бөгөөд хуульд заасны дагуу Өрийн удирдлагын стратегийг УИХ-д өргөн барихаар ажиллаж байна.
1.3.		Засгийн газар Монголбанкт хамтран улсын гадаад өрийн үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлэх	2015 оны эхний хагас жил	Сангийн яам, Монголбанк		Төлөвлөгөө хэрэгжиж эхэлнэ.	Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний төлөвлөгөөний төслийг боловсруулаад байна. Энэхүү төлөвлөгөөний төслийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдөр хэлэлцүүлж, зарчмын хувьд дэмжсэн. Цаашид гадаад өрийн үйлчилгээний төлөвлөгөөг Монголбанкт хамтран сайжруулсны үндсэн дээр Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн хамт хуульд заасан хугацаанд багтаан Засгийн газар, УИХ-д өргөн барихаар ажиллаж байна.
1.4.		Бага орлоготой иргэд, жижиг, дунд үйлдвэрийн татварын хувь хэмжээг бууруулах замаар дэмжлэг үзүүлэх	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжиж, ажлын байр нэмэгдэнэ.	“Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тус тус заасны дагуу татварын багц хуулийн төслийг боловсруулж, татварын хууль тогтоомжийг энгийн ойлгомжтой, бизнес эрхлэлт, хөрөнгө оруулалтыг дэмжсэн, олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцсэн, хууль хоорондын хийдэл, зөрчилгүй болгох зорилт тавиад байна.
1.5.	Татварын бодлогоор эдийн засгийг дэмжих	Татварыг энгийн ойлгомжтой болгон олон улсын жишигт нийцсэн шинэчлэл хийх	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		Хуулиуд хэрэгжиж эхэлсэн байна.	Одоогийн байдлаар Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын (НӨАТ) тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хөрөнгийн албан татварын тухай хуулийн төсөл, Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төсөл дээр Улсын Их Хурлаас байгуулсан Ажлын хэсэг ажиллаж, хэлэлцүүлэгт бэлтгэж байна. НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр эцсийн хэрэглэгчийн төлсөн НӨАТ-ын 2 хувийг буцаан олгох замаар бэлэн төлбөр тооцоо, далд эдийн засгийг бууруулах, НӨАТ-ын босгыг 50 сая төгрөг болгон нэмэгдүүлэх замаар жижиг бизнес эрхлэгчдийн НӨАТ-ын дарамтыг бууруулах, НӨАТ-ын хуулийн ойлгомжгүй, зөрчилтэй зарим зүйл заалтуудыг шинэчлэн сайжруулах, энгийн ойлгомжтой болгох зэрэг зарчмын олон асуудлыг тусгасан. Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлээд байгаа Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын (ААНОАТ) тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр уул уурхай, ашигт малтмал, нефтийн бүтээгдэхүүний импорт,

						<p>газрын тосны экспорт, үүрэн холбооны операторын үйлчилгээ, архи, спирт, тамхи үйлдвэрлэл зэргээс бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс илүүгүй орлоготой аж ахуйн нэгжид оногдуулах татварын хэмжээг нэг хувь болгон өөрчлөх буюу 90 хувиар хөнгөлөх асуудлыг тусгасан. Сангийн яамнаас, Татварын ерөнхий хууль, ААНОАТ-ын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлийг тус тус, Ашигт малтмал, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн төсөл, Өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын тухай хуулийн төсөл зэрэг татварын багц хуулийн төслийг олон нийтэд танилцуулахаар ажиллаж байна. Эдгээр хуулийн төслөөр жижиг, дунд хэмжээний ажил, үйлчилгээ эрхлэгчид тогтмол татвар ногдуулах зэрэг асуудлыг тусгахаар төлөвлөж байна.</p> <p>Төсвийн нэгдмэл байдлыг хангаж, ил тод байдлыг дээшлүүлэн, алдагдлын хэмжээг зохистой түвшинд хүргэх зорилтыг хангах үүднээс бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн зарлагыг эрэмбэлэн, нэн шаардлагатай зардлыг эхлэн санхүүжүүлэх төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлж байна.</p>
2.	<b>Санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, мөнгөний бодлогоор эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих</b>					
2.1.	Улсын Их Хурлын 2014 оны 69 дүгээр тогтоолоор баталсан мөнгөний бодлогын үндсэн зорилт, чиглэлийг хэрэгжүүлж ажиллах	Хөтөлбөрийн зээлээс Монголбанкны тэнцэлд үлдэх хэсгийг Засгийн газарт шилжүүлэх	2015 оны эхний хагас жил	Монголбанк Сангийн яам	Хөтөлбөрийн үлдсэн хэсгийг Засгийн газарт шилжүүлж авсан байна.	<p>Монголбанкнаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийг зээлүүдээс үлдэх хэсгийн Засгийн газарт шилжүүлэн авах ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Монголбанкнаас үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлийн үлдэгдэл 2015 оны 6 дугаар сарын эцэст 535.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болохоор байгаа бөгөөд эдгээр зээлийг олгогдсон салбар, дэд хөтөлбөр бүрийн онцлогийг харгалзан хууль, тогтоомжуудад нийцүүлэн Засгийн газарт шилжүүлэн авч Монголбанк хөтөлбөрийн зээл олгох үйл ажиллагаанаас гарна. Зээлийн үлдэгдлийг шууд шилжүүлэн авах асуудал 2015 оны төсөв, өрийн тооцоонд тусгагдаагүй тул дэд хөтөлбөр, салбарын онцлогийг харгалзан 2-3 арга замаар Засгийн газарт шилжүүлэн авахаар төлөвлөж ерөнхий схемийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд 3 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанд танилцуулж дэмжүүлсэн.</p>
2.2.	Банкны салбарт эрсдэл хуримтлагдах, зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болохоос сэргийлэх арга хэмжээ авах		2015 оны эхний хагас жил	Монголбанк	Санхүүгийн тогтвортой байдал хадгалагдана.	<p>Банкуудын хэвийн зээлд байгуулах эрсдэлийн сангийн зардлыг банкуудынтатвар ногдуулах орлогоос хасч тооцуулах талаарх саналыг Монголбанкнаас Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2015.01.13-ны өдрийн хурлаар танилцуулсан. Сангийн яамнаас Татварын багц хуулийг шинэчлэхээр ажиллаж байгаа бөгөөд дээрх саналыг</p>

						<p>холбогдох хуулийн төсөлд тусгахаар тогтсон болно.</p> <p>Монголбанкнаас банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх талаар судалгаа хийж, холбогдох саналыг боловсруулсан. Монголбанк дээрх чиглэлээр холбогдох шийдвэрийг гаргахаар ажиллаж байна. Зээлийн эргэн төлөлтөд тасалдал үүсэхээс сэргийлж Банкуудад Монголбанкнаас хийж байгаа иж бүрэн шалгалтын удирдамжийн дагуу банкуудын 40 том зээлийн чанарт тогтмол үнэлгээ өгч, шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.</p>
2.3.	Санхүүгийн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах	Банкны салбарт системийн шинжтэй эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулах хүрээнд Монголбанк болон төрийн бусад холбогдох байгууллагад шаардлагатай мэдээлэл солилцох тогтолцоо, хяналт, зохицуулалтын арга хэрэгслийг сайжруулах	2015 оны эхний хагас жил	Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл	Эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоо сайжирсан байна.	<p>Хөрөнгийн зах зээл болон даатгалын үйл ажиллагаатай холбоотой СЗХ-ноос тавих хяналт шалгалтын үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоонд шат дараалан шилжүүлэх чиглэрээр дараах дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж байна. Цаг үеийн хэрэгцээ шаардлага бүхий асуудлуудыг тухай бүр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулан ажиллаж байна. Тухайлбал, 2015 оны 1 дүгээр улиралд СТБ3 2 удаа (1 дүгээр сарын 13 болон 3 дугаар сарын 13-ны өдрүүдэд) хуралдан, нийт 21 асуудал (Сангийн яамнаас 10, Монголбанкнаас 8, Санхүүгийн зохицуулах хорооноос 3 асуудал)-ыг хэлэлцэж шийдвэрлэсэн болно.</p>
<b>3. Нийгмийн халамжийн бодлогыг зорилтот бүлэгт чиглүүлэх</b>						
3.1.		Хөдөлмөр эрхлэлтийн сангийн хэмжээг тогтвортой хадгалж, ажил эрхлэлтийг дэмжих	2015 он	Хөдөлмөрийн яам		<p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 7 дугаар хуралдаанаар “Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих”, “Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг хадгалах”, “Залуучууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” зэрэг 5 хөтөлбөр шинэчлэн батлагдаж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэгдэв.</p> <p>Их дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчдийг эзэмшсэн мэргэжлийн дагуу үйлдвэрлэлийн ажлын байранд дагалдуулан сургах, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, хувиараа болон бүлгийн зохион байгуулалтаар үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд нь багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гарааны дэмжлэг үзүүлэн байнгын ажлын байртай болгох зорилгоор “Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага төгсөгчдийн</p>
3.2.	Ажил эрхлэлтийг дэмжих	Ажлын байр хадгалах болон их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2015 он	Хөдөлмөрийн яам	Ажилгүйдлийн түвшин 6.9 хувь болсон байна.	
3.3.		Эрсдэлийн түвшин өндөртэй ажлын байранд ажиллагсдыг ажил олгогч амь нас, эрүүл мэндийн даатгалд	2015 он	Хөдөлмөрийн яам		

		заавал даатгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх				хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг шинээр батлан хэрэгжүүлж эхэлсэн.
3.4.		Инфляци, бүтээмжтэй уялдуулан цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бий болгох	2015 он	Хөдөлмөрийн яам		<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд доорх заалтуудыг тусгаад байна. Үүнд:</p> <p>Уг хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.17 дэх заалтад “Эрсдэлийн түвшин их ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд тухайн ажилтны 36 ба түүнээс дээш сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр заавал даатгуулна. Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг ажил олгогч хариуцна.” Мөн 28 дугаар зүйлийн 28.3 дахь заалтад “Захиалагч, ерөнхий болон туслан гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангах, болзошгүй тохиолдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас ажилтанд учирсан хохирлыг нөхөн төлөх, амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах зэрэгт зайлшгүй шаардагдах хөрөнгө, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгана.” гэсэн заалтуудыг тус тус тусгасан болно.</p> <p>Мөн уг хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулан, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн барихаар бэлэн болгоод байна.</p> <p>Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тооцох татварын хөнгөлөлтийг нэмэгдүүлэн өөрчлөх хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, холбогдох яамдад санал авахаар хүргүүлээд байна. Мөн төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх тооцоолол хийж, холбогдох яам болон нийгмийн түншлэлийн талуудтай хамтран ажиллаж байгаа болно.</p>
3.5.	Эдийн засгийн хүндрэлийн нийгмийн эмзэг хэсэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх	2015-2016 он	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Ядуурлын түвшин 26.0 хувь болсон байна.	<p>1. Зорилтот бүлэгт чиглэсэн Хүнс тэжээлийн тусламж үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: 2015 оны Төсвийн тухай хуульд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд олгох хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний төсвийг нэмэгдүүлж 18 гаруй тэрбум төгрөг байхаар батлагдсан. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрах иргэдийн тоог нэмэгдүүлж, энэ хөтөлбөрийн хүрээнд 24 мянга гаруй өрхийн 135 мянга орчим иргэн хоол хүнсний тусламж авч байна.</p> <p>Хүнсний эрхийн бичиг хүүхдэд 5000 төгрөг байсныг 6500 төгрөг, насанд хүрэгсдэд 10000 төгрөг байсныг 13000 төгрөг болгон тус тус нэмэгдүүлсэн.</p>



3.6.		Ажилгүйдлийн тэтгэмж авах хугацааг сунгах болон ажилгүй болсон иргэдийг богино хугацаанд дэмжихэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	2015 он	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн яам			<p>2. Орлого багатай иргэдийн Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүрэн болон хэсэгчлэн төлөх ажлын хүрээнд: Ядуурлын шугамаас доогуур байгаа өрхийн амьжиргааны судалгааг гаргаж, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа шаардлагатай нийт 65 мянга гаруй иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн эрсдлийг хуваалцаж, эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэх нөхцөл боломжоор хангаж байна.</p> <p>2. Ажилгүйдлийн тэтгэмж авах хугацааг сунгах болон ажилгүй болсон иргэдийг богино хугацаанд дэмжихэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд: Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд ажилгүйдлийн тэтгэмж авах хугацааг сунгах талаар нэмэлт өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл бэлдэж байна. Ажилгүйдлийн даатгалын сангаас олгох сургалтын зардлыг шинэчлэн тогтоохоор судалгаа тооцоо хийж байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүй болон ажилгүй болсон иргэдийг ажилд зуучлагдах хүртэл богино хугацаанд түр орлогоор дэмжих зорилгоор Нийтийг хамарсан ажлын арга хэмжээг зохион байгуулж байна.</p>
4.	<b>Монгол Улсад итгэх хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх</b>						
4.1.	Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах	Хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчныг тогтвортой байлгаж, бизнест ээлтэй орчныг бүрдүүлэх	2015-2016 он	Засгийн газрын бүх түвшинд		Бизнесийн орчин сайжирч, хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.	Япон Улстай байгуулсан "Эдийн засгийн түншлэлийн тухай" хэлэлцээрийн Хөрөнгө оруулалтын бүлэг нь Монгол, Японы хөрөнгө оруулагчдад илүү баталгаатай эрх зүйн тогтвортой орчинг бий болгож байгаа юм. Энэхүү хэлэлцээрээр Монгол Улс, Япон Улсын хооронд 2001 онд байгуулсан "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр"-ийг сайжруулж, боловсронгуй болгосон. Учир нь 2001 оны хэлэлцээр нь нийт 16 зүйл заалттай, агуулгын хувьд дутагдалтай, маргаан дагуулах асуудлууд ихтэй байсан юм. Харин энэхүү хөрөнгө оруулалтын бүлэг нь 20 зүйл, заалттай бөгөөд агуулгын хувьд илүү ойлгомжтой, тодорхой болгосон. Ингэснээр хоёр орны хөрөнгө оруулагчдын хооронд үүсэж болох маргаантай асуудлуудыг багасгах боломж бүрдэнэ.
4.2.		Хөрөнгө оруулагчдад чанартай, шуурхай, найрсаг, ойлгомжтой, хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлэх зорилгоор нэг цэгийн цахим үйлчилгээг	2015 оны 2 дугаар хагас жил	Хөрөнгө оруулалтын газар		Нэг цэгийн үйлчилгээ нэвтэрсэн байна.	Гадаадын хөрөнгө оруулагчдад мэдээлэл, зөвлөгөө өгөх "Хөрөнгө оруулагчийн менежер" үйлчилгээг нэвтрүүлж, 2014 оны байдлаар 840 гаруй, 2015 оны эхний 2 сарын байдлаар 50 гаруй хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээг хүргээд байна. 2014 оны байдлаар Гадаадын хөрөнгө оруулалт бүхий 335 аж ахуйн нэгж, 2015 оны эхний 2 сарын байдлаар 36 аж ахуйн нэгж шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. УБЕГ, ХЭБГ-тай уулзаж, тэдний цахим програмыг нэг цэгийн цахим үйлчилгээнд нэгтгэх талаар ярилцсан. Төслийн талаар мэдээллийг KOICA

		нэвтрүүлэх				байгууллагад бичгээр хүргүүлсэн боловч төслийн саналыг Сангийн ямаар дамжуулж тус байгууллага хүлээн авна гэсэн хариу ирсэн. Мөн EBRD-д танилцуулж уулзалт хийсэн.
4.3.		Хөрөнгө оруулагчдад учирдаг дарамт, шахалт, хүнд суртлыг багасгах зорилгоор Хөрөнгө оруулалтын газарт Хөрөнгө оруулагчтай холбоотой аливаа асуудлаар үйлчилгээ үзүүлэх, хамгаалах эрхийг олгох	2015 оны 2 дугаар хагас жил	Хөрөнгө оруулалтын газар	Эрх олгогдсон байна.	<p>Хөрөнгө оруулалтын газарт тодорхой эрх олгох асуудлыг зохицуулсан баримт бичгийн төслийг боловсруулж байна. Дэлхийн банк, Олон Улсын Санхүүгийн корпораци /IFC/-тэй хамтран “Хөрөнгө оруулагчийн гомдлыг зохицуулах” төслийн бэлтгэл ажлыг ханган ажилласан бөгөөд ЭЗХЯ, ГХЯ, УУЯ, АМГ, МҮХАҮТ зэрэг газруудтай уулзалт хийн төслийн талаар санал солилцов. ОУСК нь төслийн бэлтгэл ажлын хүрээнд ААН-үүдээс судалгаа авч, судалгааны тайлангаа танилцуулахаар бэлтгэж байна.</p> <p>2015 оны 4 дүгээр сарын 2-3-нд зохион байгуулагдах “Монголын эдийн засгийн форум”-ын хүрээнд хөрөнгө оруулалтын орчин, сайжруулах арга зам салбар хуралдааныг зохион байгуулахаар бэлтгэл ажил хийж байна.</p> <p>“Монгол Улсын хөрөнгө оруулалтын үндэсний хэлэлцүүлэг” арга хэмжээг 2015 оны 4 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэ хэлэлцүүлгээр хөрөнгө оруулалтыг либералчлах, өрсөлдөх чадварыг тодорхойлох, хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр Засгийн газрын байгууллагуудын хооронд санал солилцоно.</p>
4.4.		Монгол Улсын бизнесийн орчны талаар зөв ойлголт өгч, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалт татах зорилгоор гадаад орнуудын Засгийн газар, хөрөнгө оруулалт хариуцсан байгууллагатай хамтарч ажиллах	2015-2016 он	Хөрөнгө оруулалтын газар	2-оос доошгүй оронтой хөрөнгө оруулалт харилцан дэмжих гэрээ байгуулсан байна.	<p>Улаанбаатар хотод 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Канадын талтай “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн III цахим хурлыг хийж, байгуулах чиглэлээр ажиллаж байна. Япон улстай байгуулсан “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахтай холбогдуулан олон нийтэд хэлэлцээрийн тухай нарийвчилсан мэдээллийг өгч эхлээд байна.</p> <p>Казакстан Улсын “Казнексинвест” байгууллагатай 2015 онд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар ажиллаж байна.</p> <p>2015 оны эхний 2 сарын байдлаар 7-н арга хэмжээг зохион байгуулж оролцоод байна. Тухайлбал: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Чех, Герман улсад хийсэн айлчлалын үеэр зохион байгуулагдсан бизнес форумыг Чехийн Худалдааны танхим, Германы Ази-Номхон далайн холбоотой, Ерөнхий сайдын Япон улсад хийсэн айлчлалын үеэр зохион байгуулагдсан бизнес форумыг ЖАЙКА-тай хамтран зохион</p>

						байгууллаа.
						<p>Гадаад улс орнуудад хөрөнгө оруулалтын элч төлөөлөгчийг томилон ажиллуулах асуудлаар 20 гаруй Өргөмжит Консулын газруудтай ажиллаж байна.</p> <p>“Дэлхийн хөрөнгө оруулалтын форум-2014” арга хэмжээний мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд 43 улстай Монгол Улсын байгуулсан хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих гэрээнд дүн шинжилгээ хийлгүүлэх хүсэлтийг НҮБ-ын ХХБХ-ын Хөрөнгө оруулалт, аж ахуйн нэгжийн хэлтсийн Олон улсын хөрөнгө оруулалтын гэрээний хэсгийн даргад албан ёсны захидал боловсруулан хүргүүлэв.</p>
4.5.		Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, боломжийн талаар гадаад сурталчилгааг өргөжүүлж, санхүүжүүлэхэд бэлэн төслүүдийг хөрөнгө оруулагчдад танилцуулах	2015-2016 он	Хөрөнгө оруулалтын газар	Хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна.	<p>Бүх яамдууд болон Нийслэлийн ЗДТГазар, ААН-үүдээс хэрэгжүүлэхийг хүссэн төслийн мэдээллийг тогтоосон загварын дагуу авч, онлайн төслийн санг бүрдүүлж эхлээд байна. Одоогийн байдлаар Засгийн газрын болон хувийн хэвшлийн 30-аад төслийг хүлээн авч <a href="http://www.investmongolia.com">www.investmongolia.com</a> цахим хуудсан дээр англи, монгол хэл дээр байршуулаад байна. Төслийг сурталчлах ажлыг тус газрын мэдээллийн санд байгаа хөрөнгө оруулагчдад түгээхээр бэлтгэж байна.</p> <p>Хөрөнгө оруулагчдад зориулсан хөтөч номыг англи, орос, хятад хэл дээр бэлтгэсэн ба 2015 оны эхний 2 сарын байдлаар англи хэл дээр 500 ширхэгийг хэвлүүлээд байна.</p> <p>Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах Ажлын хэсэгт ажиллан, хэлэлцээрийн үр дүнд талуудын ашиг сонирхлыг хангасан гэрээний төслийг боловсруулсан. Хэлэлцээрийн явцад зарчмын зарим асуудлыг нарийвчлан судлах шаардлага гарсан тул түр завсарлаад байна.</p>

#### Дунд хугацаанд үр дүн гарах арга хэмжээ

<b>5. Төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого авч хэрэгжүүлэх</b>						
5.1.	Засгийн газрын хуримтлалын тогтолцоог сайжруулах	Эдийн засгийн хүндрэл, онцгой нөхцөл байдал үүсэхэд санхүүгийн дутагдалд орохгүй байх хэмжээнд төсвийн тогтворжуулалтын санг бүрдүүлэх, сангийн	2015 оны эцэс жил	Сангийн яам	Тогтворжуулалтын сангийн хөрөнгийн хэмжээ нэмэгдэнэ.	<p>Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийн удирдлага, тус сангийн ашиглалтын талаарх хууль, эрхзүйн орчин, өөрчлөлт оруулах шаардлагын талаар тайлбар, танилцуулга бэлтгэн яамны удирдлагад танилцууллаа. Яамны удирдлагаас Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийг Ирээдүйн өв сангийн тухай хууль батлагдсан нөхцөлд байгуулагдах хөрөнгийн удирдлагын корпорациар гүйцэтгүүлэх, шаардлагатай бол Сангийн яам гадаад, дотоодын мэргэжлийн хуулийн этгээдээр удирдуулж болохоор хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах чиглэл өгсөн. Одоогоор Төсвийн тогтворжуулалтын сангийн</p>

		санхүүгийн менежментийг бие даасан, хараат бус нэгжээр хийлгэж, илүү үр ашигтай болгох чиглэлээр хууль эрх зүйн орчныг өөрчлөх					хөрөнгийн удирдлагын асуудал Засгийн газрын тусгай сангийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тодорхойгүй бөгөөд хоорондоо зөрчилтэй байдлаар тусгагдсан байгааг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тодорхой болгон шийдвэрлэхээр хуулийн төслийг боловсруулсан. Харин тус сангийн ашиглалт буюу санд хөрөнгө төвлөрүүлэх, сангаас зарцуулалт хийх, сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнах харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулах нь зүйтэй гэж үзэж мөн уг хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн санал боловсруулсан. Хуулийн төслүүдийг яамны удирдлагад эцэслэн танилцуулж, улмаар Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлэхээр бэлтгэж буй Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн төсөл, Ерөнхийлөгчийн Тамгын газраас УИХ-д өргөн мэдүүлж байгаа Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төслүүдийг дагалдуулан өргөн бариад байна.
5.2.		Ирээдүйн өв сангийн тухай хуулийг Улсын Их Хурлаар батлуулж, Үндэсний баялгийн сан байгуулах	2015 оны 2 дугаар хагас жил	Сангийн яам		Баялгийн сан байгуулагдсан байна.	<p>Хуулийн төслийг өргөн барив. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан Монгол Улсад олон улсын жишигт нийцсэн баялгийн санг байгуулах, хууль эрх зүйн орчныг бий болгох, холбогдох хуулийн төсөл боловсруулах чиглэлээр Ажлын хэсгийг байгуулсан. Тус Ажлын хэсэгт Ерөнхийлөгчийн Тамгын газар, Сангийн яам, холбогдох талуудыг оролцуулсан. Ерөнхийлөгчийн Тамгын газар (Ерөнхийлөгчийн зөвлөх, ажлын хэсгийн гишүүд), Сангийн яам хамтран Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төслийг боловсруулж, холбогдох судалгааг хийж, хэлэлцүүлгийг 2-3 удаа Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэдэх Иргэний танхимаар олон нийт, мэргэжлийн төлөөллийг орлоцуулан хэлэлцүүлсэн. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төсөл, түүний танилцуулгыг Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлээ.</p> <p>Засгийн газрын хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн тухай Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэл гарсан.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулсан Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төслийг 2014 оны 10 дугаар сарын 13-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн байна. УИХ-ын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад багтсан.</p>

**Хоёрдугаар чиглэл.Эдийн засгийн өсөлтийг дэмжих**

**Богино хугацаанд үр дүн гарах арга хэмжээ**

6.	<b>Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх</b>
----	--

6.1.	Зогсонги байдалд орсон томоохон төслүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Оюутолгойн төслийн хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийж, далд уурхайн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	2015 оны 2 дугаар хагас жил	Монгол Улсын сайд		1.2 тэрбум ам.доллар	“Оюутолгой” ХХК шинэчилсэн ТЭЗҮ-ийг УУЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүлээлгэж өгөхөөр бэлтгэл ажлыг хийж байна.
6.2.		Тавдугаар цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэгчтэй Засгийн газар цахилгаан болон дулааны эрчим хүч худалдан авах гэрээ, газар ашиглах гэрээг байгуулж, төслийг эхлүүлэх	2015 оны эхний хагас жил	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам		240.0 сая ам.доллар	Концессын гэрээг “Фифт Комбайнд Хийт энд Пауэр Планта” ХХК-тай 2014.6.20-ны өдөр байгуулсан бөгөөд Эрчим хүчний сайдын 2013.02.28-ны өдрийн 27 дугаар тушаалаар байгуулагдсан инженерийн шугам сүлжээнүүдийн асуудлуудыг шийдвэрлэх Ажлын хэсгүүд концесс эзэмшигчидтэй хамтран ажиллаж байна.  “Дулааны V станц төсөл”-ийн дулааны эрчим хүч худалдах, худалдан авах болон эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний хэлцлийг 5 удаа хийсэн байна.
6.3.	Хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	Тавантолгойн цахилгаан станцын барилгын ажлыг эхлүүлэх	2016 он	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам		Төслийн бэлтгэл ажил хангагдсан байна.	
6.4.		Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх	2015 оны 2 дугаар хагас жил	Зам, тээврийн яам		Барилгын ажил эхэлсэн байна.	Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар “Эрдэнэт хотоос Овоотын уурхайн чиглэлд барих төмөр замын төсөл”-ийг шууд гэрээ байгуулан хэрэгжүүлэхээр Концессын гэрээ байгуулахыг Зам, тээврийн сайдад даалгасан.
7.	<b>Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлуулах</b>						
7.1.	Алтны олборлолтыг нэмэгдүүлэх	Алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх, алтыг худалдан авах нөхцөлтэйгээр урьдчилгаа	2015 оны эхний хагас жил	Монголбанк Уул уурхайн яам		20 тонн алт олборлоно.	Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар “Алтны олборлолтыг нэмэгдүүлж, эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” асуудлыг хэлэлцэж, Засгийн газрын 2015 оны 94 дүгээр тогтоолыг баталсан. Монгол банк 30 аж ахуйн нэгжийн 103 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүсэлтийг Уул уухайн яаманд ирүүлсэн байна. Мөн алт олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор 24 аж ахуйн нэгжид 141 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт, нийт 244 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай тооцоо гарсан бөгөөд Засгийн газрын 2015 оны 94 дүгээр тогтоолоор алтны ордуудад санхүүгийн

		олгох, урьдчилан худалдан авах зэргээр олборлолтыг нэмэгдүүлэх				дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэсэн. Монголбанкнаас алтны санхүүжилтэд шаардагдах гадаад эх үүсвэрийг бүрдүүлэх талаар гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
7.2.		Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, алтны тодорхой ордуудыг ашиглах	2015 оны эхний хагас жил	Уул уурхайн яам	10 тонн алт олборлоно.	<p>Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, алтны тодорхой ордуудыг ашиглах</p> <p>Тусгай зөвшөөрөлөө сэргээх хүсэлтээриүүлсэх тухай зарыг АМГ-аас хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон утсаар холбогдох аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэх арга хэмжээ авсан. Үүний дагуу Уул уурхайн Сайдын 2015 оны 46 дугаар тушаалаар УУЯ, БОНХАЖЯ, АМГ, МХЕГ-ын төлөөллүүд оролцсон Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна.</p>
7.3.	Төмрийн хүдрийн баяжмалын экспортыг нэмэгдүүлэх	Төмрийн хүдрийн баяжмалын борлуулалтыг нэмэгдүүлэх	2015 оны 2 дугаар хагас жил	Уул уурхайн яам, Гадаад хэргийн яам	2016 оноос жил бүр 10 сая тн-оос доошгүйг экспортолно.	<p>Төмрийн хүдрийн баяжмалын экспортыг нэмэгдүүлэхийн тулд гадаадын зах зээлд борлуулсан төмрийн хүдэр, баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох аргачлалыг Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, баталсан. Шинэ аргачлал батлагдсанаар аж ахуйн нэгжүүд нөөц ашигласны төлбөрөө бодит үнэлгээгээр тооцуулж, татварын хөнгөлөлт эдлэх боломжтой болсон. Энэ аргачлалаар Төмрийн хүдрийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг Засгийн газрын 2007 оны 88-р тогтоолд заасны дагуу Австралийн төмрийн хүдэр үйлдвэрлэгчдээс Хятадын ган үйлдвэрлэгчид нийлүүлж байгаа Dampeir/Hedland боомтын FOB үнэ. /www.umetal.com/ цахим хуудсанд нийтэлсэн үнэд үндэслэн тооцож байсныг өөрчилж, гэрээний үнийг үндэслэн нөөц ашигласны төлбөр ногдуулахболсноор төмрийн үдэр, төмрийн хздрийн баяжмалын экспорт нэмэгдэнэ гэж тооцож байна.</p> <p>Засгийн газрын 2007 оны “Биржийн нэр зарлах тухай” 88 дугаар тогтоол, 2014 оны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 220 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулан, шаардлагатай тохиолдолд төмрийн хүдэр экспортлогч аж ахуйн нэгжийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулахаар</p>

						тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрийг гаргуулсан.
7.4.		Цементийн үйлдвэрийн төслүүдэд Хөгжлийн банкнаас санхүүжилт олгох	2015 оны эхний хагас жил	Хөгжлийн банк		<p>Хөтөлийн “Цемент шохой” ХХК-ийн үйлдвэрийн өргөтгөлд зориулан Бэйзмент ХХК-д Хөгжлийн банкнаас 5 жилийн хугацаатай 8.8 % хүүтэй 60 сая ам долларын зээл олгосон. Мөн бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд 20 тэрбум төгрөгийн зээлийг 5.5%-ийн хүүтэй олгосон. Дээрх зорилт арга хэмжээг авч ажилласаны үр дүнд Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн өргөтгөлийн ажил дуусаж, жилийн хүчин чадал 1.0 сая тонноор нэмэгдсэн.</p> <p>Засгийн газрын 2014 оны 164 дүгээр тогтоолоор Дорноговийн шохойн чулууны ордод түшиглэн цементийн үйлдвэр байгуулахаар ажиллаж буй МАК ХХК-д 87,5 сая ам.доллар олгохоос 18.2 сая ам.доллар, Монполимет ХХК-д 65 сая ам.доллар олгохоос 33 сая ам.доллар санхүүжилтийг Чингис бондын хөрөнгөөс гаргаад байна.</p> <p>МАК ХХК-ийн үйлдвэр 2015 оны 4 дүгээр улиралд, Монполимет ХХК-ийн үйлдвэр 2016 оны эхний улиралд ашиглалтад орно.</p>
7.5.	Импортыг орлох үйлдвэрийг дэмжих	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг өөрчилж, төрөөс дотоодын бараа, бүтээгдэхүүнийг түлхүү худалдан авах замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		<p>Монгол Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолын 2 дугаар чиглэл 7 дугаар хэсэгт Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлуулах заалтын 7.5-д заасны дагуу Импортыг орлох үйлдвэрийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг өөрчилж, төрөөс дотоодын бараа, бүтээгдэхүүнийг түлхүү худалдан авах замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих” ажлын хүрээнд дараахь арга хэмжээг авч ажиллах юм. Үүнд:</p> <p>Нэг. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасныг үндэслэн Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн баримт бичигт дээрх зүйлд заасны дагуу дотоодын аж ахуйн нэгжүүдийн ирүүлсэн тендерийн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 10 хувиар, ажил гүйцэтгэх тендерийн үнийг 7.5 хувиар хийсвэрээр бууруулж тооцон давуу эрх олгож ажиллахыг захиалагч нарт үүрэг болгох тухай Засгийн газрын 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 18 дугаар тогтоол батлагдсан билээ. Тус тогтоолын биелэлтийг хангаж ажиллах чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгож, үр дүнг хариу мэдэгдэж байхыг даалгах.</p> <p>Хоёр. Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар Засгийн газраас санаачлан боловсруулж УИХ-д 2014 оны 5 дугаар сард өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил</p>

							үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эргүүлэн татахаар тогтсон билээ. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эргүүлэн татсантай холбогдуулан Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулан дахин хуулийн төслийг боловсруулахаар ажиллаж байна.
7.6.	Экспортыг нэмэгдүүлэх	Гадаад орнуудтай байгуулсан хөнгөлөлтийн ерөнхий тогтолцоог /GSP/ өргөжүүлэх замаар экспортын үйлдвэрлэлийн эрэлтийг нэмэгдүүлэх	2015 оны эхний хагас жил	Аж үйлдвэрийн яам, Гадаад хэргийн яам		Экспортын үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлт нэмэгдсэн байна.	Манай Улс "Эдийн засгийн түншлэлийн тухай" хэлэлцээрийг Япон Улстай байгуулснаар хөдөө аж ахуй, оёмол сүлжмэл бүтээгдэхүүн, савхин эдлэл, хүнд үйлдвэрийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг японы зах зээлд илүү хөнгөлөлттэй нөхцөлөөр боломж бүрдэж, хоёр талын худалдаа нэмэгдэж, үйлдвэрлэл өсч, ажлын байр шинээр нэмэгдэх болно.
<b>8. Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх</b>							
8.1.	Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар эдийн засгийг дэмжих	Олон улсын зах зээлд Төрийн банкны бонд гаргах	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		300.0 сая ам.долларын бонд босгосон байна.	Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн хурлаар "Төрийн банк үнэт цаас гаргах тухай" хэлэлцээд гадаад валютын бага хүүтэй, урт хугацаатай санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор Төрийн банк 300.0 сая ам.доллар хүртэлх хэмжээний үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалахыг Засгийн газрын 84 дүгээр тогтоолоор дэмжсэн болно. Энэ хүрээнд үнэт цаас арилжаалах үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна.

#### Дунд хугацаанд үр дүн гарах арга хэмжээ

<b>9. Дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх</b>							
9.1.		Туул-Сонгины усны нөөцийн цогцолбор байгуулж, усан цэнэгт цахилгаан станц байгуулах төслийг эхлүүлэх /Барих-ашиглах-шилжүүлэх/	2016 он	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам		Төслийн ажил эхэлсэн байна.	Концессын гэрээ 2014 оны 4 дүгээр сарын 8-нд байгуулагдсан. Барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.
9.2.	Концессын гэрээ байгуулсан төслүүдийг эрчимжүүлэх	Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны авто замын төслийг эхлүүлэх /Барих-ашиглах-шилжүүлэх/	2016 он	Зам, тээврийн яам, Аж үйлдвэрийн яам		Барилгын ажил эхэлсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 399 дүгээр тогтоолоор "Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны авто зам төсөл"-ийн концессын гэрээг "Чингис лэнд девелопмент групп-Шинэ хөгжлийн зам" ХХК-тай байгуулахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт зөвшөөрсөн. Гэрээ байгуулан зураг төслийн ажил хийгдэж байгаа. Концессын гэрээг 2014 онд байгуулсан боловч хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүй байгаа.
9.3.	Концессын гэрээ байгуулах	Багануурын 700 МВт-ын цахилгаан станцын	2016 он	Эрчим хүчний яам,		Барилгын ажил	Концессын гэрээ байгуулах эрхийг 2015 оны 3 дугаар сарын 9-ний 88 тоот тогтоолоор олгоод байна. "Багануур



	шатанд байгаа төслүүдийг эрчимжүүлэх	төслийн барилгын ажлыг эхлүүлэх /Барих-ашиглах-шилжүүлэх/		Аж үйлдвэрийн яам		эхэлсэн байна.	Пауэр” ХХК-тай Концессын гэрээг 3 дугаар сард багтаан гэрээнд гарын үсэг зурахаар ажиллаж байна.
9.4.		Чандганы 600 МВт-ын цахилгаан станцын төслийн барилгын ажлыг эхлүүлэх /Барих-ашиглах- шилжүүлэх/	2016 он	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам		Төслийн бэлтгэл ажил хангагдсан байна.	Концессын гэрээний хэлэлцээг эхлүүлэх ажлын хэсгийг шинэчлэх асуудлыг ХОГ хийж байна.
9.5.		УБ -Мандалговь, Багануур-Өндөрхаан-Чойбалсан, Багануур-Чойр, Чойр-Сайншанд-Замын-Үүдийн чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барих ажлыг эхлүүлэх	2016 он	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам		Төслийн ажил эхэлсэн байна.	Багануур-Өндөрхаан-Чойбалсан чиглэл нь Чандганын цахилгаан станцын төслийн хамт хэлэлцээг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Улаанбаатар-Мандалговь, Багануур-Чойр, Чойр-Сайншанд-Замын-Үүдийн чиглэлийн ажлыг Концессын зүйлийн жагсаалтад оруулах асуудлыг судалж байна.
9.6.		Дорнодын 100 МВт-ын цахилгаан станц төслийн барилгын ажлыг эхлүүлэх /Барих-ашиглах- шилжүүлэх/	2015 оны эхний хагас жил	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам		Төслийн ажил эхэлсэн байна.	2 дахь оролцогчтой хэлэлцээг эхлүүлэх урилгыг явуулаад байна.
9.7.		Хөшигийн хөндийн нисэх буудал болон нийслэлийг холбох хурдны авто замын төслийг эхлүүлэх /Барих-шилжүүлэх/	2015 он	Зам, тээврийн яам, Аж үйлдвэрийн яам			Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 89 дүгээр тогтоолоор “Улаанбаатар хот-Хөшигтийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хурдны авто зам” төслийг БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тогтож, уг асуудлыг судалж, шийдвэрлүүлэхийг Сангийн сайд, Зам, тээврийн сайд нарт даалгаад байна.
9.8.		Аймгийн төвийг нийслэл хоттой болон бусад аймгуудтай холбох авто замын төслүүдийг хэрэгжүүлэх /Барих-шилжүүлэх/	2016 он	Зам, тээврийн яам, Аж үйлдвэрийн яам		Барилгын ажил эхэлсэн байна.	Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 70 дугаар тогтоолоор “Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай зам”, “Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замын төгсгөлөөс Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам” төсөл, “Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замын төгсгөлөөс Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 112.7 км хатуу хучилттай авто зам”, “Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам” төслүүдийн концессын гэрээг байгуулахыг, Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 87 дугаар тогтоолоор “Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай зам”, “Баянхонгор-Алтай чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам”, “Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам”, “Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам”, “Мандал сум (Зүүнхараа) чиглэлийн 15.8 км хатуу хучилттай авто зам” төслүүдийн концессын гэрээг байгуулах эрхийг холбогдох сайд нарт олгоод байна.

9.9.		Концессын бусад төслүүдийн бэлтгэл ажлыг хангаж, эхлүүлэх	2016 он			Бэлтгэл ажил хангагдсан байна.	Засгийн газрын 2013 оны 317 тоот тогтоолд байгаа шууд гэрээгээр байгуулах, уралдаант шалгаруулалт явуулах төслүүдийн материалыг бэлтгэж байна.
9.10.		Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ажлыг эхлүүлэх /Барих-ашиглах-шилжүүлэх/	2016 он	Зам, тээврийн яам		Барилгын ажил эхэлсэн байна.	Бичигтийн боомтыг цогцоор нь хөгжүүлэх бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн төслийн хамт боловсруулах, боомтын дэд бүтцийн асуудал болон тус боомтод чөлөөт бүс байгуулах талаар санал боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.
9.11.	Экспортын болон транзит тээврийг нэмэгдүүлэх	Төмөр замын босоо тэнхлэгийн замыг хос болгох, Улаанбаатар хотын дундуур тавих төмөр замыг Богд уулын урдуур тойруулан барих ажлыг эхлүүлэх	2016 он	Зам, тээврийн яам		Бэлтгэл ажил хангагдсан байна.	Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 110 дугаар тогтоолоор “Богдхан” төмөр зам болон “Улаанбаатар” холимог тээврийн логистик төвийг барьж байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг Азийн хөгжлийн банкнаас үзүүлэх техник туслалцааны хүрээнд зохион байгуулахаар шийдвэрлээд байна. Мөн тус төмөр зам болон логистик төвийг барьж байгуулах хөрөнгийн асуудлыг Азийн хөгжлийн банктэй эцэслэн тохиролцохоор тогтсон байна.
10.	<b>Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлуулах</b>						
10.1.	Алтны олборлолт-ыг нэмэгдүүлэх	Улсын хилийн зурвас газар дахь алтны зарим ордуудыг тусгай хамгаалалттай газрын ангиллаас гаргах Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	2015 он	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Уул уурхайн яам		Улсын Их Хурлаас холбогдох шийдвэр гарсан байна.	Энэ асуудлыг судлан санал боловсруулахыг Засгийн газрын 2015 оны 94 дүгээр тогтоолоор холбогдох сайд нарт даалгасан. 30 хувийн биелэлттэй.
10.2.	Зэсийн баяжмал, цэвэр зэсийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг өргөтгөх	Эрдэнэтийн-Овоо ордын төвийн хэсгийг ашиглах замаар тус ордын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	2016 он	Уул уурхайн яам		Барилгын ажил эхэлсэн байна.	Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших MV-000011 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Эрдэнэтийн Овооны зэс-молибденийн ордын төвийн хэсгийг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг ШУТИС-ийн харъяа “Уул уурхайн хүрээлэн”, ОХУ-ын Москва дахь “Гипроцветмет” хүрээлэнгийн зураг төсөл, эрдэм шинжилгээний инженерүүд хамтран боловсруулсан. Уул уурхайн сайдын 2014 оны 106 дугаар тушаалаар шинжээчийн хэсгийг байгуулж уг техник, эдийн засгийн үндэслэлд шинжээчийн дүгнэлтийг гарган улмаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар 2014 оны 7 дугаар сарын 9-ны өдөр хэлэлцүүлж хүлээн авсан. Тус ордын төвийн хэсгийг ил аргаар ашиглах талаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
10.3.		Цагаан суваргын ордын төслийн санхүүжилтийг шийдвэрлэж, төслийг эхлүүлэх	2016 он	Уул уурхайн яам, Сангийн яам		Төслийн бэлтгэл ажил дууссан байна.	УИХ-ын “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” Улсын Их Хурлын 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 10-т заасан “Цагаан суварга”-ын ордод төр хувь эзэмших шаардлагагүй гэж үзсэн тул уг төслийн санхүүжилтийн асуудлыг Монголын Алт ХХК

						хариуцахаар болсон.
10.4.		Зэс хайлуулах үйлдвэр байгуулахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх	2016 он	Аж үйлдвэрийн яам, Уул уурхайн яам		Төслийн санхүүжилт шийдвэрлэгдсэн байна.
10.5.		Тарифын болон тарифын бус саад тогторыг бууруулж, ОХУ, БНХАУ болон бусад томоохон зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр экспортлох боломжийг бүрдүүлэх	2016 он	Аж үйлдвэрийн яам, Гадаад хэргийн яам		Тариф буурсан байна. Зарим бараанд ногдуулсан квотыг нэмэгдүүлсэн байна.
10.6.		Япон улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулж, худалдаа, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах	2015 эхний хагас жил	Гадаад хэргийн яам		Япон улсад экспортлох хэмжээ нэмэгдсэн байна.
10.7.	Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх	Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрийн төслүүдийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх, эх үүсвэрийг нэмэгдүүлэх	2015-2016 он	Аж үйлдвэрийн яам, Хөгжлийн банк		300.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
						Монгол Улс БНХАУ, Евро Азийн эдийн засгийн холбоо, АНУ, Канад, Солонгос зэрэг улс орон болон эдийн засгийн байгууллагатай эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлыг судалж байна. БНХАУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах талаар судалгаа хийх АХ-ийг байгуулсан. Монгол Улсаас БНХАУ руу экспортолж байгаа болон экспортлох боломжтой бараанд ноогдож байгаа импортын тарифын хувь хэмжээг бууруулах талаар нарийвчилсан судалгааг хийж байна. Евро Азийн эдийн засгийн комиссын Зөвлөлийн гишүүн (Сайд) Т.Д.Валовая Монгол Улсад 2015 оны 3 дугаар сарын 25-наас 28-ны өдрүүдэд айлчлал хийсэн. Энэ айлчлалын үеэр тарифын болон тарифын бус хориг саадыг багасгах ажлын хүрээнд цаашид авах арга хэмжээний талаар санал солилцсон болно. Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Япон улсад айлчлалын үеэр "Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр" болон түүнийг хэрэгжүүлэх хэлэлцээрт тус тус 2015 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Токио хотод гарын үсэг зурсан. Талуудын гарын үсэг зурсан "Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр"-ийг 2015 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж соёрхон баталсан. Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрийн төслүүдийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх, эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Хөгжлийн банкны 70,0 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгохоор Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 66 дугаар тогтоол гарсан. Энэ эх үүсвэрээс орон нутагт 9,1 тэрбум төгрөгийг хуваарилсан. Хөнгөлөлттэй зээлийг олгох шалгуур үзүүлэлтийг Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 40 дугаар тушаалаар баталж, журмыг боловсронгуй болгохоор ажиллаж байна. Төслүүдийг санхүүжүүлэх эх үүсвэр, боломжийн талаарх судалгаа хийгдэж байгаа ба Хөгжлийн банктай хэд хэдэн удаагийн уулзалт хийсэн. Мөн аж үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төслүүдийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх тухай Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэж байна.

10.8.		Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үндэсний үйлдвэрлэгчдэд Хөгжлийн банкнаас хөнгөлөлттэй зээл олгох	2015-2016 он	Аж үйлдвэрийн яам, Хөгжлийн банк		80.0 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.	<p>“Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох зээлийн эх үүсвэрийн талаарх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар удаа дараа хэлэлцүүлж, 2014 онд 26 дугаар тэмдэглэл, 198 дугаар тогтоол, 217 дугаар тогтоол тус тус батлагдсан. Засгийн газрын 217 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын дагуу Засгийн газрын баталгаа гаргасан үнэт цаас (Үйлдвэржилтийн бонд)-ыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс 110,4 (Нэг зуун арван тэрбум дөрвөн зуун сая) тэрбум хүртэл төгрөгийг арьс ширийг гүн боловсруулах болон, түүгээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн төсөлд арилжааны банкаар дамжуулан зээлдүүлэхээр тогтсон.</p> <p>Арьс ширний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх зорилгоор арьс ширийг гүн боловсруулах болон, түүгээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлийн 220 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл хүссэн 102 төсөл ААН-үүд ирүүлснийг Төсөл шалгаруулах зөвлөлөөр хэлэлцэж, харилцагч банкаар нь судлуулсан.</p> <p>Өнөөдрийн байдлаар 63,4 тэрбум төгрөгийн зээлийг 38 үйлдвэрлэгчдэд олгоод байгаа бөгөөд 12 үйлдвэрлэгчдэд 13 тэрбум төгрөгийн зээл олгохоор арилжааны банкны зээлийн хорооны шийдвэр гарсан. Эдгээр үйлдвэрлэгчидтэй АУЯ гэрээ байгуулахаар бэлтгэл хийгдэж байна.</p>
10.9.		Ноос, ноолуур, сүү, хүлэмж болон оёдлын салбарын төслүүдэд Хөгжлийн банкнаас хөнгөлөлттэй зээл олгох	2015-2016 он	Аж үйлдвэрийн яам, Хөгжлийн банк		100.0 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.	<p>Оёдол, нэхмэл, сүлжмэлийн үйлдвэрүүдэд техник, технологийн шинэчлэл хийхэд зориулж, Чингис бондын санхүүжилтээс Засгийн газрын 2013 оны 141 дүгээр тогтоолоор ноосны салбарт 45.0 сая ам.доллар, оёдлын салбарт 13.5 сая ам.долларын хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>2015 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн Голомт банкнаас ирүүлсэн мэдээллээр Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбарын 32 аж ахуйн нэгжийн 28,8 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий төслийг судалсанаас 16 аж ахуйн нэгжийн 6,9 тэрбум төгрөгийн зээлийг олгохоор дэмжигдсэн бөгөөд үүнээс одоогийн байдлаар 16 аж ахуйн нэгжүүдэд 3,03 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Ноос боловсруулах 51 компаний 150 тэрбум төгрөгийн төслийн зээлийн материалыг Голомт банкинд хүргүүлсэн бөгөөд үүнээс 2015 оны 2 дугаар сарын 12-ны байдлаар нийт 16 компанийн төсөлд 51,08 тэрбум төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн боловч 12 компанид 23,695 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна.</p> <p>Зээлийн үр дүнд ноос ноолуурын салбарын хүчин чадал самнах үйлдвэрлэлд 2,4 %, зэрэх үйлдвэрлэлд 20%, сүлжих үйлдвэрлэлд 22% тус тус өссөн байна.</p> <p>Засгийн газрын 2013 оны 3 сарын 30-ны өдөр 126-р тогтоолоор ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх</p>

						санхүүжилтийн эх үүсвэрийн гуравны нэгтэй тэнцэх 68,8 сая хүртэлх ам.долларын /106,3 тэрбум төгрөг/ зээл батлагдсан. Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн “Ноолуурын салбарт дэмжлэг үзүүлэх тухай” 165 дугаар тогтоолоор Засгийн газрын 2013 оны 126 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, зээлийг төслийн санхүүжилтэд зарцуулах боломжтой болсон. Зээлийн хэрэгжилтийн байдал: Ноолуур боловсруулах 80 компанийн 132,5 тэрбум төгрөгийн төслийн зээлийн материалыг Голомт банкинд хүргүүлсэн бөгөөд үүнээс 2015 оны 2 дугаар сарын 12-ны байдлаар нийт 44 компанийн төсөлд 88,2 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.
10.10	Чөлөөт бүс болон казино байгуулах, гадаад сурталчилгааг нэмэгдүүлэх, визийг хөнгөвчлөх, жуулчдын аюулгүй, ая тухтай аялах боломжийг бүрдүүлэх зэргээр аялал жуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэх	2015-2016 он	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Аж үйлдвэрийн яам, Гадаад хэргийн яам			Иргэд зорчих нөхцөлийг хөнгөвчлөх ажлын хүрээнд 2015 оны эхний улиралд Мальта, Албани Улстай “Цахим дипломат болон албан паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас харилцан чөлөөлөх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулахаар төслийг эцэслэн тохиролцсон бөгөөд ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Түүнчлэн Хорват, Турменистан Улстай “Дипломат болон албан паспорттой иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг эцэслэн тохиролцсон бөгөөд Туркменистан Улстай байгуулах визийн хэлэлцээрийн төслийг Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн Туркменистан Улсын Гадаад хэргийн сайдын МУ-д хийх айлчлалын хүрээнд байгуулахаар бэлтгэж байна. Бразил Улстай “Иргэдийг богино хугацааны визийн шаардлагаас чөлөөлөх тухай ноот бичиг”-ийн төслийг эцэслэн тохиролцоод байгаа бөгөөд ойрын хугацаанд уг асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэхээр бэлтгэж байна. Унгар Улстай байгуулсан визийн хэлэлцээрийг шинэчлэн байгуулахаар ажиллаж байна. Казиногийн тухай хуулийн төслийг боловсруулж 2015 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлээд байна. 2015 оны 3 дугаар сарын 2-ноос 12-ны өдрүүдэд ХБНГУ-д зохион байгуулагдсан “ИТБ-Берлин 2015” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол Улс түнш орноор оролцож өөрийн орны түүх, соёл угсаатны өв, нүүдлийн соёл, иргэншлийн талаар дэлхийн улс орнуудад таниулах сурталчлах ажлыг амжилттайгаар зохион байгуулав. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Засгийн газарт өргөн барихаар бэлдээд байна. Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулах үүднээс Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлыг барих санхүүжилтийг шийдвэрлэх - Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлыг барих санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр 2015 оны 2 сарын 2-ны өдрийн Засгийн
10.11	Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулах үүднээс Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлыг барих санхүүжилтийг шийдвэрлэх	2015-2016 он	Сангийн яам, Зам, тээврийн яам	2014 онд 190.0 сая ам.доллар	Аялал жуулчлалын орлого 250.0 сая ам.доллар т хүрсэн байна.	

							<p>газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулах “УБ хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төслийн нэмэлт зээлийн хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэж дэмжээд УИХ-ын холбогдох байнгын хороодтой зөвшилцөх үүрэг өгч 7 дугаар тэмдэглэл гарсан.</p> <p>УИХ-ын Төсвийн Байнгын хороо болон Эдийн засгийн Байнгын хороо хэлэлцэн хэлэлцээрийн төслийг дэмжсэн. 2015 оны 2 сарын 16-ны өдөр Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооноос тус төслийн хэрэгжилтэд аудитын дүгнэлт гаргуулах, төслийн үйл ажиллагаатай танилцах ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг төслийн үйл ажиллагаанд аудит хийж дуусч байна.</p>
10.12	Импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих	Дэлхийн худалдааны байгууллагатай тохирсон хэмжээний дотор импортын зарим бараанд ногдуулах гаалийн татварыг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих	2016 он	Сангийн яам, Аж үйлдвэрийн яам	5.0 хувь	Зарим барааны татвар 10-20 хувь болсон байна.	
10.13		Нүүрснээс шингэн болон хийн түлш гарган авах үйлдвэрүүдийг зарим нүүрсний ордуудад түшиглэн байгуулах төслийн бэлтгэл ажлыг хангах	2016 он	Аж үйлдвэрийн яам		Төслийн бэлтгэл ажил хангагдсан байна.	
10.14		Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх	2016 он	Аж үйлдвэрийн яам		Барилгын ажил эхэлсэн байна.	ЗГ-ын 2015 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэл гарсан.
10.15		Эгийн голын усан цахилгаан станцын төслийн бэлтгэл ажлыг хангаж, эхлүүлэх	2016 он	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам		Төслийн бэлтгэл ажил хангагдсан байна.	Хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай ЗГ-ын 2015 оны 89 дүгээр тогтоол, ЗГ-ын 3 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэл гарсан.
11.	<b>Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх</b>						
11.1.	Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар эдийн засгийг дэмжих	Засгийн газрын баталгааны болон зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйл ажиллагааг	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		Хууль батлагдаж хэрэгжиж эхэлсэн байна.	Зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор аймаг, нийслэл, банкны мэргэжлийн холбоо, төсвөөс зээл хүсэгч иргэн, аж ахуйн нэгжийн зээлд батлан даалт гаргах зорилгоор зээлийн батлан даалтын санд хөрөнгө хуваарилж болох, тус хөрөнгийг зөвхөн тухайн орон нутгийн зээл хүсэгч иргэд, аж ахуйн нэгжийн зээлд батлан даалт гаргахад зарцуулах, мөн сангийн одоогийн

		өргөжүүлэх				удирдлагын бүтэц, засаглалыг сайжруулах хүрээнд Монголын банкны холбоотой хамтран ажиллах талаар холбогдох зохицуулалтыг тусган Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна. Хуулийн төслийг УИХ-ын 2015 оны Хаврын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
11.2.		Хөрөнгө оруулалтын санг гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэх	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		<p>Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 36 дугаар тэмдэглээр Олон улсын санхүүгийн байгууллагатай хэлэлцээр хийж, хөрөнгө оруулалтын сангийн эхний үе шатыг хэрэгжүүлэх зорилгоор 100 сая ам.долларын хэмжээтэй санхүүгийн амлалт гаргахыг Хөгжлийн банкинд зөвшөөрч, Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах болон үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, бодлогын зөвлөмж өгч ажиллахыг Сангийн яаманд даалгасан, Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 61 дүгээр тэмдэглэлд “Хөрөнгө оруулалтын сан”-ийн тухай хэлэлцсэний дагуу Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулахад МУ-ын Хөгжлийн банкруу бодлогын чиглэл хүргүүлээд байна.</p> <p>Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажлын хүрээнд TDB капитал ХХК, Улаанбаатар ХХК нар хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллах хүсэлтээ тавьсаны дагуу олон улсын нэр хүнд бүхий JP Morgan-г оруулж ирэх асуудал нь хэлэлцээрийн шатанд явж байна.</p>
11.3.		Үндэсний давхар даатгалын корпораци байгуулах	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		<p>Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль батлагдсантай холбоотойгоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн үүсгэн байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн. Малын индексжүүлсэн давхар даатгалын тогтолцоо бий болсноор зуд, байгалийн гамшгаас учирсан хохиролд улсын төсвөөс их хэмжээний зардал гаргадаг байсныг өөрчилж, төр, даатгалын компани, малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээд хамтран хариуцаж, төсвийн ачаалал багасах, цаашид олон улсын давхар даатгалд нэгдсэн журмаар хамрагдах боломж бүрдэх юм.</p> <p>Олон улсын туршлагаас үзэхэд үндэсний давхар даатгалын компанийг төрийн дэмжлэг оролцоотойгоор анхлан байгуулж, 3-5 жилийн дараагаар хувийн хэвшилд үе шаттайгаар шилжүүлэх нь үр дүнтэй байдаг байна. Тухайлбал, БНСУ-ын Корейн Ре, БНВУ-ын Вьетнам Ре, БНХАУ-ын Чайна Ре зэрэг үндэсний давхар даатгалын компаниудыг ийм арга замаар байгуулсан байна. Манай улсын хувьд олон улсын дээрх туршлагад үндэслэн үндэсний давхар даатгалын компанийг байгуулах боломжтой бөгөөд Дэлхийн банктай хамтран урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулж дуусаад байна. Монгол Улс жилд 30 орчим сая ам.долларыг давхар даатгалд төлж байгаа урсгалыг багасгахад Үндэсний давхар даатгалын</p>

							корпораци тодорхой үүрэг гүйцэтгэнэ.
11.4.		Үйлдвэржилтийг дэмжсэн санхүүгийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бизнес эрхлэгчдэд учирдаг эрсдлийг багасгах, санхүүжилтийн өртгийг бууруулах зорилгоор хувийн хэвшилтэй хамтран экспортын даатгалын компани, тоног төхөөрөмжийн лизингийн компани байгуулах	2015 оны эхний хагас жил	Сангийн яам Хөгжлийн банк		Экспортын даатгалын компани, тоног төхөөрөмжийн лизингийн компаниуд байгуулагдсан байна.	Үйлдвэржилтийг дэмжсэн санхүүгийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих зорилгоор санхүүгийн түрээсийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг EBRD-ийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд холбогдох яамд болон банкуудын холбоо, хуульчидттай хамтран судалж байна.
11.5.		Барилга угсралтын ажлын даатгал, эмчийн хариуцлагын даатгал, хуульчийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хуулийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		Хууль батлагдаж, хэрэгжиж эхэлсэн байна.	
12.	<b>Эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийх, бизнесийн орчинг сайжруулах</b>						
12.1.	Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, оновчтой болгох	Түлш, эрчим хүчний үнэ тарифыг үе шаттайгаар чөлөөлж, тус салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, эрчим хүчний шинэ эх үүсвэр болон дамжуулах шугамыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд шилжүүлэх	2015 оны эхний хагас жил	Эрчим хүчний яам		Улсын Их Хурал, Засгийн газраас холбогдох шийдвэр гарсан байна.	
12.2.		Төрийн өмчийн хороо болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагын тогтолцоог корпорацийн засаглалд шилжүүлж, бие даасан байдал, үр ашгийг дээшлүүлэх, Засгийн газраас төрийн өмчит	2015 оны эхний хагас жил	Төрийн өмчийн хороо		Улсын Их Хурал, Засгийн газраас холбогдох шийдвэр гарсан байна.	Төрийн өмчтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгоор хууль санаачлагчдаас боловсруулсан хуулийн төслүүдийг нэгтгэн боловсруулах үүрэг бүхийг ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 137 дугаар захирамжаар байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалыг 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар баталсан.



		компанитай зөвхөн татвар ногдуулах, ногдол ашиг хуваарилах байдлаар харилцдаг болох чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, батлуулах					
12.3.		Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар батлуулж, төрийн өмчит компаниудыг Хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах тогтолцоог бий болгох	2015 оны эхний хагас жил	Сангийн яам, Төрийн өмчийн хороо		Улсын Их Хурал, Засгийн газраас шийдвэр гарсан байна.	Төрийн өмчийг Хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах арга хэмжээний хууль эрх зүйн орчинг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар бүрдүүлсэн. Тус хуульд шинээр олон нийтэд хувьчлах компанийн хувьцааг санал болгох, IPO хийх эрх зүйн зохицуулалтуудыг тусгасан. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг хэлэлцэж УИХ-ын тогтоолын төслийг хүргүүлээд байна.
12.4.	Газрын харилцааг боловсронгуй болгох	Газрыг эдийн засгийн харилцаанд бүрэн оруулж, урт хугацаанд тогтвортой хөрөнгө оруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Газрын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	2015 оны 2 дугаар хагас жил	Барилга, хот байгуулалтын яам		Хууль батлагдаж хэрэгжиж эхэлсэн байна.	Ерөнхий сайдын 2015 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 62 дугаар захирамжаар "Газрын тухай багц хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах үүрэг бүхий" ажлын хэсэг байгуулагдсан. Газрын тухай багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд болон хуулийг даган гарах журмуудад газрыг эдийн засгийн харилцаанд бүрэн оруулах, түүнтэй холбогдох хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны тогтвортой байдлын зохицуулалтыг тусгах асуудлаар гүйцэтгэлийн хугацаатай төлөвлөгөөний дагуу судалгаа хийж, боловсруулах асуудлыг зохион байгуулан ажиллаж байна.